

ХАР ТАМХИ, МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН
БАЙЦААГЧ М.ЭНХБОЛДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 05

Улаанбаатар хот

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин	
		3	Хүрэх түвшин	4	Хүрсэн түвшин / биелэлт
1	2	3	4	5	
НЭГ. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХХЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө /валют-ийгулсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангасан байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	85%	- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл ажиллагаа хууль хяналтын байгууллагуудтай 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, харьяа гаалийн газар хороодыг хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаахтай холбоотой авадсан гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн удирдамжаар ханган ажилласан байна. /1,2 улирал/	- 2024 онд мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлын хүрээнд хэлтсийн чиг үүргийн хүрээнд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрыг хариуцан ажилсан. Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг заавдсан нийт 6 удаагийн үйлдлийг таслан зогсоож, мэргэжил арга зүйн удирдамжаар ханган ажилласан. 1. [redacted] (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) 2. 15 төрлийн наалт /стикер/ (Хар тамхи тодорхойлогч төхөөрөмжөөр шинжилж үзэхэд [redacted] гэх хяналтад байдаг бодис, 4 төрлийн наалт /стикер/-ын 2-т нь [redacted] үлдсэн 2-т нь [redacted] рага— [redacted]) – 15 ширхэг (Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүс) 3. [redacted] 500 мл (ЧХОУНБГТ) 4. [redacted] 7.32 грамм (Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүс) 5. [redacted] – 7.32 грамм (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) 6. [redacted] 94.4 грамм (Монгол шуудан нисэх гаалийн хяналтын бүс) холбогдох хууль тогтоомжийн дагуу цагдаа, магнуулын байгууллагад шилжүүлсэн болно. Хугацаа: 2024.01.01–2024.06.05 Хувь: 100

2	Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	86.6%	Гадаад, дотоодын хууль сахиулах байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах, харьяа гаалийн газар, хороодыг мэдээллээр хангасан байна. /I.2-р улирал/	<u>Дотоодын хууль сахиулах байгууллага</u> - Лавлагаа, мэдээлэл, нотлох баримт гаргуулах тухай Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг нийт 58 албан бичгийн хариуг хугацаанд нь өгч, шийдвэрлэсэн. - Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс хооронд 2024 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх, таслан зогсоох чиглэлд хамтран ажиллах төлөвлөгөөг батлан ажиллаж байна. - Өнгөрсөн онд Тагнуул, Цагдаа, Гаалийн байгууллагын дарга нарын хамтран баталсан [redacted] хамтарсан арга хэмжээний үр дүнгийн хэлэлцүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ГЕГ-ын 4 давхрын хурлын өрөөнд зохион байгуулж "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис", "Түүх соёлын дурсгалт зүйлс", "Алт"-ыг Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчил, гэмт хэргийн онцлог, гэмт этгээдүүдийн ашиглаж буй арга хэлбэр, хилийн хяналтын байгууллагуудын хэрэгжүүлж буй хяналт, шалгалтад үнэлэлт, дүгнэлт хийж цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээ, харилцан мэдээлэл солилцох хамтын ажиллагааны талаар хэлэлцэж, улмаар 3 байгууллагын төлөөлөл дараах нэгдсэн санал, дүгнэлтийг гаргаж тус тусын байгууллагын удирдлагад танилцуулах, "Суваг-2" хамтарсан ажилгааны удирдамжийн төслийг боловсруулж батлуулахаар тохиролцсон. Уг арга хэмжээний нэгдсэн санал, дүгнэлтийг ГЕГ-ын даргад танилцуулсан ба [redacted] арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. - Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газрын Хоёрдугаар хэлтэс хооронд байгуулагдсан Хамтарсан хяналт шалгалт удирдамжийн дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх таслах зогсоох чиглэлд хамтран ажиллаж байна. - Гаалийн тухай хуулийн [redacted] Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналт дор хүргэх аргыг хэрэглэж болно гэсэн заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар Тагнуулын байгууллагатай [redacted] удаа, Цагдаагийн байгууллагатай [redacted] удаа илгээмжийг хяналтан дор хүргэх арга хэмжээг зохион байгуулсан. Хугацаа: 2024.01.01-2024.06.05 Хувь: 100
---	--	------------------------	-------	---	---

3	Хар тамхи, мөнгө угаах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	93.3%	-Хар тамхины хууль бус эргэлтэй тэмцэх чиглэлээр гаалийн газар, хороодод эрх бүхий байгууллагуудтай хамтран 2 сургалт зохион байгуулж холбогдох мэдээллээр чиглэл зөвлөмж хургуулж ажиллана. /1.2-р улирал/ -Олон нийтэд хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах гэмт хэргийн хор хөнөөлийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр анхааруулга, сэрэмжлүүлгийг цахим орчинд 1-ээс доошгүй удаа түгээж, үр дүн, хүртээмжийг дүгнэсэн байна. /1.2-р улирал/	- Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар хороодод Дэлхийн гаалийн байгууллага (WCO)-ын Бүс нутгийн зөрчлийн мэдээлэл солилцох төв (RILCO)-өөс Зөрчлийн мэдээллийн сүлжээ (SEN)-ээр ирүүлсэн Ази номхон далайн бүс нутаг (RILCO/AP)-ийн гаалийн байгууллагуудын 2023 онд илрүүлсэн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараатай холбоотой 2023 оны зөрчлийн мэдээллийг зурагт танилцуулга байдлаар нэгтгэж 9 хуудас бүхий мэдээллийг харьяа гаалийн 18 газар хороодод хавсралтаар хургуулсан; - ГЕГ-ын ОНХА-тай хамтран Гаалийн ерөнхий газрын www.customs.gov.mn цахим хуудасны Гаалийн хяналт бүрдүүлэлт, зөрчил цэсний Зөрчил хэсэгт Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй тэмцэх чиглэлээр "Бусдын дайвар ачаа авахаас татгалзах" тухай сэрэмжлүүлэг мэдээ бэлтгэн хүргэсэн. - Хамтын ажиллагааны хүрээнд ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газарт ашиглагдаж байсан "Body scan" буюу зорчигчийн биед биет үзлэг хийх зориулалт бүхий тоног төхөөрөмжийг ЧХОУНБ-ын зорчигчийн ирэх талд суурилуулан гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. ЧХОУНБ-ын зорчигчийн ирэх талд зорчигчийн биед үзлэг хийх тоног төхөөрөмж нь эвдэрсэн байсан ба олон улсын ирэх чиглэлийн зорчигчид хяналт, шалгалтыг бүрэн тавих боломжгүй байсан. Мөн уг арга хэмжээг МҮОНРТ сурвалжилж олон нийтэд түгээснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг биедээ нууж улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болж байна гэх урьдчилан сэргийлэх, анхааруулга мэдээллийг нийтэд түгээсэн.
4	Мэдээллийн санд мөнгө угаах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой дүн шинжилгээ хийсэн байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	90%	CAIS системийн өгөгдлийн сан, нээлттэй эх сурвалжийн мэдээллийг ашиглан мэдээлэл хүлээн авч, боловсруулж, дүн шинжилгээ хийгдсэн байна. Дүн шинжилгээнд тулгуурлан урьдчилан сэргийлэх мэдээлэл	-УХШИГТ-ын гаалийн хяналтын бүсэд [REDACTED] илгээсэн илгээмжээс сэжиг бүхий үл мэдэгдэх бодис илэрсэн бөгөөд тус бодисыг хар тамхи тандан илрүүлэгч [REDACTED] төрлийн төхөөрөмжөөр шинжилж үзэхэд үр дүн үзүүлээгүй тул нээлттэй эх сурвалжаас судлан, дүн шинжилгээ хийж [REDACTED] мансууруулах бодис болохыг урьдчилсан байдлаар тогтоосон. Хугацаа: 2024.01.01-2024.06.05 Хувь: 100

				зөвлөмжөөр хангасан байна. /I улирал/	
5	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	100%	1. Гаалийн байгууллагын "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд нэгжийн чиг үүрэгт хамаарах ажлуудыг хэрэгжүүлж биелэлтийг хангаж ажилласан. 2. Гаалийн ерөнхий газрын 2023 оны "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланд нэгжийн чиг үүрэгт хамаарах ажлын тайланг гаргаж хүргүүлсэн.	- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гаалийн байгууллагын саналыг хүргүүлж 2024 оны хагас жилийн биелэлт, тайланг хүргүүлэн ажиллаж байна. - "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний биелэлт, тайлан"-г хүргүүлж 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд туслуулах саналыг хүргүүлсэн. - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд туслуулах саналыг хүргүүлсэн.
6	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	80%	Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажилласан байна. /I,2-р улирал/	- Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотойгоор харьяа гаалийн газар, хороодыг цаг тухай бүрд холбогдох хууль тогтоомж (жишээлбэл: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Зөрчлийн тухай, Гаалийн тухай хуулиуд г.м)-ийн дагуу заавар, зөвлөмж, удирдажжаар ханган ажилласан. Үүний хүрээнд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 2 удаагийн үйлдлийг таслан зогсоож, эзэн холбогдогч болон ноглох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгсөн. - "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлын хэсэгт орж ажиллан гаалийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх чиглэлд санал хүргүүлж ажилласан.
7	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	0%	Нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг таньж тогтоон, сан	Хугацаа: 2024.01.01-2024.06.05 Хувь: 100 Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг эрчимжүүлэх


				бүрдүүлсэн байна. Дүн шинжилгээ хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг тухай бүр авсан байна	зорилгоор Гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-ийн "Эрсдэлтэй зорчигчийн сан"-гийн мэдээллийг шинэчлэх, тус санг баяжуулах зорилгоор 2021 оноос хойших хугацаанд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд холбогдож байсан эсхүл Эрсдэлтэй зорчигчийн санд зайлшгүй оруулах шаардлагатай гэх иргэдийн мэдээллийг авахаар ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. Дээрх гэмт хэрэгт холбогдсон иргэдийн мэдээллийг эрсдэлийн санд оруулснаар Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа эрсдэлтэй зорчигчийн мэдээллийг шинэчлэх шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах ач холбогдолтой болно.
8	Үүрэг биелэлт даалгаврын	Хэрэгжилт гүйцэтгэлээр	100%	Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулах чиглэл өгч удирдлагаар хангаж ажилласан байна. /I,2-р улирал/ ГЕГ-аас Харьга гаалийн газар хороодод өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлийн дагуу хийгдсэн ажлуудыг дүгнэж, биелэлтийг хангуулж ажиллана. /I,2-р улирал/ УИХ, ЗГ, УАБЗ, Сангийн яам болон бусад төрийн болон төрийн тусгай чиг	Хугацаа: 2024.01.01-2024.06.05 Хувь: 100 -Тайлант хугацаанд улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газарт дараах хугацаатай үүрэг даалгавар, ажлын чиглэлийг хүргүүлж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Хар тамхи, мансууруулах бодис болон Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдах тохиолдол өсөн нэмэгдэх хандлагатай байна. Иймд дараах ажлын чиглэлийг хүргүүлж байна. Үүнд: - Хар тамхи, мансууруулах бодисыг гаалийн агуулахад хадгалж буй хугацаанд үрэгдсэн, алга болсон тохиолдол гарсан тул энэ төрлийн барааг хадгалах сейфтэй болох; - Нарийн хэмжилт хийдэг баталгаат жинтэй болох; - Хар тамхитай тэмцэх чиглэл хариуцсан холбоо баригч томилж, нэр, холбоо барих утасны дугаарыг ирүүлэх; - Сар бүрийн 05-ны өдрийн дотор хавсралтаар хүргүүлсэн Мэдээлэл авах хүснэгтийн дагуу хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэг, зөрчлийн талаарх тайланг ирүүлж байх; - Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг гаалийн хилээр нэвтрүүлэх үед Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйл болон Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ыг удирдлага болгон, мөрдөж ажиллах. Мөн хар тамхи, мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис, эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг улсын хилээр

			үүргийн байгууллагуудаас ирүүлсэн албан даалгавар, чиглэл, үүргийг хангаж ажилласан байна.	хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэг, зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэхдээ Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газар, Олон нийттэй харилцах албанаас чиглэл авч байхыг үүрэг болгож байна.	
9	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	90%	Өмнөх оны ажлын цаг ашиглалтын оноог дээшлүүлж ажиллана. Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах, гар утасны бэлэн байдлыг 24/7 цагаар ханган, ирсэн цагаа бүртгүүлж, тухайн өдөр гүйцэтгэх ажил үүргээ танилцуулж, чиглэл авч ажиллана. /I-р улирал/	Тайлант хугацаанд тасалсан өдөр байхгүй. 2024 оны ээлжийн амралтыг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс авсан бөгөөд ажлын 12 хоног дутуу байхад ажилдаа орсон. Нэгжийн чиг үүргийн онцлогоос хамаарч алба хаагчид илүү цагаар ажиллах, гар утасны бэлэн байдлыг 24/7 цагаар ханган ажиллаж байна.
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	95%	Хууль хяналтын байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу лавлагаа мэдээллийг боловсруулж цаг хугацаанд нь гаргаж өгнө. /I,2-р улирал/ ГЕГ-ын даргын тушаалаар болонгазрын удирдлагаас хуваарилсан байгууллагын дотоод болон гадаадтусгайлсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх Ажлын	Хугацаа:2024.01.01-2024.06.05 Хувь: 100 - Хууль хяналтын болон бусад төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу лавлагаа мэдээллийг боловсруулж нийт 58 албан бичгийн хариуг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Мөн нотлох баримт гаргуулахаар Гаалийн газар хороодод 8 алба бичиг явуулсан. - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль-ийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлын хэсэгт орж ажиллан гаалийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх чиглэлд санал хүргүүлж ажилласан. 2. Газрын удирдлагаас бусад чиг үүргийн дагуу: - Замын-Үүд дэх гаалийн газрын АЗШНЦ-2 гаалийн хяналтын бүсээр орох чиглэлд бүртгэлгүй нэвтэрсэн гэх 52 тээврийн хэрэгслийн материалыг /хил хамгаалах байгууллагаас ирүүлсэн мэдээллийг гаалийн байгууллагын мэдээллийн автоматжуулсан систем "Кайс" программын тээврийн бүртгэлтэй тулган/ шалгаж Замын-Үүд дэх гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч Г.Мөнхцоож, н.Оюунд холбогдох хэсгийг ГЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст танилцуулгаар хүргүүлсэн.

			хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллана. /I-р улирал/ Цаг үеийн шинжтэй бусад ажил, үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, хэрэгжүүлсэн байна. /I-р улирал/	- Тусгай шалгалтад тэнцэж, болзол шалгуурыг ханган ГЕГ болон харьяа газар, хороодод томилогдох 35 иргэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх сорилыг ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын алба хаагчидтай хамтран зохион байгуулж, сорил авсан. Хугацаа: 2024.01.01-2024.06.05 Хувь: 100
--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗӨРЧИЛТЭЙ
ТЭМЦЭХ ГАЗРЫН ХАР ТАМХИ, МӨНГӨ
УГААХТАЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ГҮБ



М.ЭНХБОЛД

2024. 06. 10

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ЭНХБОЛДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт, үр дүн	60	10	70	
2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, стандартын хэрэгжилт	60	10	70	
3.	Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдамж чиглэлээр хангаж ажилласан байдал	35	9	64	
4.	Үүрэг даалгаврын биелэлт	35	8	63	
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх	60	10	70	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд	100	15	

	хугацааны хамрагдах сургалтад			
2.	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх	100	15	
Дундаж оноо:			15	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	8	
4.	Дүн шинжилгээ хийх	5	
5.	Ажлын цаг ашиглалт	5	
Дундаж оноо:		6	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо:		7.3

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	67.4
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.3

5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = 95.7 (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95.7

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга



(Б.Батгэрэл)

2024.06.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

**Төрийн жинхэнэ албан хаагч:
зөвшөөрсөн:**

Гаалийн улсын байцаагч




(М.Энхболд)

2024.06.12 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Г.Энхтайван)

2024.07.26 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(Ж.Баясгалан)

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)

(огноо)